# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТОГТООЛ

1992 оны 9 сарын 11 өдөр | Дугаар А/126/212 | Улаанбаатар хот

Хотын эмнэлгийн түргэн тусламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын 1992 оны 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, нийслэлийн хүн амд үзүүлэх эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай болгох, түргэн тусламжийн автомашины ашиглалтыг сайжруулах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын түргэн тусламжийн автобаазыг түргэн тусламжийн станцтай нэгтгэн Хотын түргэн тусламжийн төв болгон өөрчлөн зохион байгуулж, төвийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Зохион байгуулалтын энэхүү өөрчлөлттэй холбогдуулан Эрүүл мэндийн яамны автобаазыг "Эмнэлэг үйлчилгээний авто бааз" болгон өөрчилж, дүрмийг нь хоёрдугаар хавсралтаар, эмнэлэг, үйлчилгээний зориулалтаар түргэн тусламжийн авто баазаас шилжүүлэн ашиглах автомашинуудыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Материаллаг бааз, хөрөнгө, санхүүгийн боломжтой зарим эмнэлгийн байгууллагуудад бие даан эмнэлэг, үйлчилгээнд ашиглах автомашиныг балансаас балансад дөрөвдүгээр хавсралтын дагуу шилжүүлсүгэй.

4. Эмнэлэг, үйлчилгээний автобаазаас үйлчлэх эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудыг тавдугаар хавсралтаар баталсугай.

5. Түргэн тусламжийн төв болон дүүргүүдийн түргэн тусламжийн 4 цэгийг холбооны хэрэгслээр найдвартай хангах асуудлыг энэ онд багтаан шийдвэрлүүлэхийг Хотын Телефон холбооны газар /Н.Чогжмаа/-д үүрэг болгосугай.

6. Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан хот, дүүргийн эмнэлгүүдийн эмнэлэг, үйлчилгээний тээврийн зардалд нэмж шаардагдах хөрөнгийг тооцож, хотын төсвөөс нэмж олгохыг хотын Санхүүгийн газар /н.Гонгор/, Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/-д даалгасугай.

7. Эмнэлэг, үйлчилгээний авто баазын автомашины үйлчилгээний тарифыг шинэчлэн баталж мөрдүүлэхийг хотын Үнийн комисс /н.Ганхуяг/, хотын Түргэн тусламжийн төв, эмнэлэг, үйлчигээний автобаазад үүрэг болгосугай.

8. Эмнэлэг, үйлчилгээний болон түргэн тусламжийн зориулалтын автомашины сэлбэг хэрэгсэл, бензин, шатахууны хэрэгцээг тооцож хангах, тэдгээрийн паркыг тодорхой бодлоготойгоор шинэчлэх арга хэмжээ зохион байгуулахыг Улаанбаатар хотын ардын хурлын гүйцэтгэх захиргааны Материал техник хангамжийн хэлтэс /н.Жигжидсүрэн/, Эрүүл мэндийн яамны Нийгэм эдийн засгийн бодлогын зөвлөл /н.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

9. Гүйлтийн норм дууссан түргэн тусламж, эмнэлэг, үйлчилгээний автомашины актанд хотын өмч хувьчлалын комиссоос санал авч, байгууллага болон эмнэлгийн ажилчдад худалдах, сэлбэгээр ашиглах тухай асуудлыг хамтран шийдвэрлэж байхыг Эрүүл мэндийн яамны Нийгэм эдийн засгийн бодлогын зөвлөл /н.Баярсайхан/, хотын Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/-т үүрэг болгосугай.

10. Шилжүүлж авсан эмнэлэг, үйлчилгээний автомашиныхаа засвар үйлчилгээ, шатахууны асуудлыг өөрсдөө бүрэн хариуцаж ажиллахыг холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

11. Хотын түргэн тусламжийн автобаазын 8 паркын автогараашийн II давхрыг эмнэлэг, үйлчилгээний автомашины зориулалтаар ашиглахыг хотын Түргэн тусламжийн төв, эмнэлэг, үйлчилгээний автобаазын дарга нарт зөвшөөрсүгэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.ЭНЭБИШ

Эрүүл мэндийн сайд, УБ хотын АДХГ-ын даргын 1992 оны ../24/ ..тоот хамтарсан тогтоолын нэгдүгээр хавсралт

# ХОТЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

**Нэг: Ерөнхий үндэслэл :**

1. Хотын түргэн тусламжийн төв/ цаашид төв гэнэ/ нь нийслэлийн хүн амд үзүүлэх яаралтай түргэн тусламж /явуулын хүргэгчид, хүүхэд, [illegible], төрөлжсөн бригад, хүүхдийн хэсэг/-ийн үйлчилгээг эрхлэн байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах хэрэгжүүлэх үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага мөн.

2. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль, дүрэм, засгийн газраас баталсан холбогдох байгууллагад эрхийн акт болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Төвийг хотын Эрүүл мэндийн газраас томилсон захирал удирдах хотын хөдөлмөрчдөд яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилго Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн газрын өмнө бүрэн хариуцна.

4. Төвд захирлын зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн гишүүд, зөвлөлийн ажиллах журмыг төвийн захирал батална.

5. Төв нь яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг нийт [illegible] хөдөлмөрчдөд ойртуулах зорилгоор нийслэлийн 4 дүүрэгт түргэн тусламжийн салбар үйлчилгээг эрхлэн байгуулж ажиллуулна.

6. Төвийн өртөг, орон тоог үндэслэсэн цалингийн санг нь Эрүүл мэндийн яам, Улаанбаатар хотын АДГХорооноос хамтран тогтооно.

7. Төвийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу Эрүүл мэндийн яам болон УБ хотын АДГ Захиргаа шийдвэрлэнэ.

8. Төвийн захирал нь жилд, бүтэн жилийн хамт олны өмнө үйл ажиллагааны тухай тайлан тавьж байна.

9. Төвийн захирал эрх хэмжээний дагуу тушаал гаргах, биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

10. Төв нь түргэн тусламжийн үйлчилгээний авто аж ахуйтай байх бөгөөд авто аж ахуй, эмнэлэг -үйлчилгээ эрхэлсэн дэд захиралтай байж болно.

11. Төв нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр: Төвийн үүрэг

Хотын түргэн тусламжийн төв нь дор дурьдсан үүрэг хүлээнэ.

Үүнд:

а/ Нийслэл хотын нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эмнэлгийн түргэн тусламжийн албаны үйл ажиллагааг оновчтой, шуурхай зохион байгуулах, түүнийг боловсронгуй болгох.

б/ Түргэн тусламжийн үйлчилгээг чирэгдэлгүй, хангах шуурхай үзүүлэхийн зэрэгцээ хөдөлмөрчдийн тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах.

в/ Түргэн тусламжийн дуудлагад шаардагдах эм, боодол, эмнэлгийн багаж, аппарат хэрэгслээр тогтмол хангаж байх.

г/ Төв нь эмч, сувилагч, жолооч зэрэг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах. Тэдгээрийн мэргэжлийн ур чадварыг системтэй дээшлүүлэх, [illegible] ахуй, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

д/ Түргэн тусламжийн үйлчилгээний автомашин, холбооны хэрэгслээр найдвартай хангах, зохистой ашиглах.

е/ Түргэн тусламжийн автомашины паркийн шинэчлэлт болон засвар үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгсэл, бензин шатахууны зохицуулалт хангалт, түүний зарцуулалт, авто машины ашиглалтад байнгын хяналт тавих, өдөр тутмын удирдлагаар хангах, бэлэн байдалд байлгах.

ё/ Түргэн тусламжийн дуудлагын эмч, жолооч, ажилчдыг хөдөлмөрийн хуулийн дагуу ээлжийн зохион байгуулалтаар хөдөлмөр хамгаалалтын горимын дагуу хатуу мөрдөх.

ж/ Ажиллагсадыг хөдөлмөрлөх болон, мөнгөөр хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн нөхцлийг хангах эрх хэмжээ өгч хэрэгжүүлэх.

з/ Түргэн тусламжийн мэдээ тайлагнах хотын хэмжээнд нэгтгэж тогтоосон хугацаанд гаргах.

Гурав: [illegible]

а. Монгол улсад мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хэмжээнд бие даасан үйл ажиллагаа явуулж, батлагдсан мөнгөний санхүү бичгийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтаа боловсронгуй болгох, орон тоо, төсөв, хөрөнгөө зохистой зарцуулах.

б/ өөрийн үйл ажиллагаатай холбогдох гэрээ хууль, тогтоомжийг боловсруулах ажлыг гардан зохион байгуулах.

в/ Эмнэлэг үйлчилгээний салбарт шинэ санаачлага, тэргүүний арга барил нэвтрүүлэх тэргүүний эмч, жолооч ажилчдыг тэр жилийн шагналд тодорхойлох, тэднийг байгууллагын зүгээс шагнаж урамшуулах.

г/ ЭМЯ, УБ хотын АХГ-тай зөвшилцсөн үндсэн дээр гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлцэл байгуулан хамтран ажиллах.

д/ Салбарын болон өөрийн үйлчилгээний чиглэлийн дагуу хөдөлмөрчидтэй ярилцлага/ зөвлөлгөөн зохион байгуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

е/ Төв нь өөрийн дүрмийг үндэслэн байгууллагын дотоод журмыг боловсруулж мөрдөнө.

ё/ Эмнэлэг-үйлчилгээний техник хэрэгслийн хэрэгцээг хангасан, мэргэжлийн ажил гаргах, хөдөлмөрчдийг чөлөөлөх, хохирлоос, болон хөдөлмөрийн сахилгыг ноцтойгоор зөрчсөн хүмүүст хууль, тогтоом-

жийн дагуу хариуцлагад хүлээлгэх.

з/ Түргэн тусламжийн автомашины гүйлтийн норм дууч цаашид ашиглах боломжгүй болсон нөхцөлд зохих журмын дагуу саналаа боловсруулж, ЭМЯ-аар шийдвэрлүүлэх;

Дөрөв: Санхүүгийн үйл ажиллагаа

а/ Төвийн хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, бусад санхүүгийн нөөцөөс бүрдэнэ.

б/ Төвийн хөрөнгийн эх үүсвэр нь орон нутгийн төсөв байна.

в/ Үндсэн ба эргэлтийн хөрөнгө оновчтой ашиглаж зарцуулах санхүүгийн ажлын нягтлан бүртгэл тооцоог бүрэн хариуцна.

г/ Хотын түргэн тусламжийн үйлчилгээтэй холбогдох гарах зардлыг улсын, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

д/ Төв нь туслах эм ахуй эдлэх зардлаар [illegible] [illegible] нэмэгдэл үйлдвэрлэл үйлчилгээ явуулж олсон орлогыг төсвийн гадуурх дансанд авч түүнийг ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон байгууллагаа тохижуулах, үйлчилгээний ажилд зарцуулна.

Энэ дүрмийг үндэслэн байгууллагын дотоод журмыг боловсруулж ажиллана.

Эрүүл мэндийн яам, Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны даргын 1992 оны А/126/212 тоот хамтарсан тогтоолын хоёрдугаар хавсралт

# ЭМНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТО БААЗЫН ДҮРЭМ

## Нэг: Нийтлэг зүйл:

1. Эмнэлэг үйлчилгээний авто бааз цаашид / автобааз /гэнэ алсын түргэн тусламж болон нийслэл хотын эрүүл мэндийн байгууллагын захиалга, дуудлагаар эмнэлэг үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг дагнан гүйцэтгэх, аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар мөн.

2. Авто бааз нь монгол улсын нийслэл Улаанбаатар хотод оршино.

3. Авто бааз нь улсын татварын байгууллагад бүртгүүлж, улсын гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын эмчилгээ, үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардлагатай тээврийн хэрэгслээр үйлчлэх үүргийг эрүүл мэндийн яам, Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны өмнө хариуцна.

4. Авто баазыг монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу Эрүүл мэндийн яам, Хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны шийдвэрээр өөрчлөн зохион байгуулах буюу татан буулгана.

5. Авто бааз нь бие даасан тайлан, тэнцэл гаргах, бусад аж ахуйн нэгж, байгууллагатай харьцах, монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуульд заасан эрх, үүрэг, хариуцлагыг эдлэх, хүлээх хуулийн этгээд мөн.

6. Тус бааз нь банк, санхүү, статистикийн байгууллагад зохих журмын дагуу тайлан мэдээгээ өгч байхын зэрэгцээ үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар жилд 1-ээс доошгүй Эрүүл мэндийн яаманд тайлагнана.

7. Авто баазын үйлчлэх авто машины тоо, тарифыг эрүүл мэндийн байгууллагын төсөв, санхүүгийн чадвар, үйл ажиллагааных нь онцлогтой уялдуулан Улаанбаатар хотын үнийн комиссоос тогтооно.

8. Авто бааз нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр: <u>Авто баазын удирдлага.</u>

1. Авто баазын өдөр тутмын үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамаар батлуулж хөдөлмөрийн гэрээ хийж томилсон дарга удирдана. Авто баазын даргын дэргэд захиргааны зөвлөл ажиллуулж болно.

2. Авто баазын даргатай байгуулах хөдөлмөрийн гэрээнд түүний ажиллах хугацаа, гэрээг байгуулагч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, олгох цалин хөлс, нийгмийн болон бусад нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл зэргийг тусгана.

3. Авто баазын дарга аж ахуйн бусад нэгжийн гишүүн, удирдлагын бүрэлдэхүүнд байхыг хориглоно. Харин хувьцаа эзэмшигч байж болно.

4. Дарга нь авто баазыг аливаа итгэмжлэлгүйгээр төлөөлж дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

а/ Авто баазын тээврийн болон засвар, үйлчилгээний төсөв гаргах түүнийг зохион байгуулж хэрэгжүүлэх, эд хөрөнгийг хуулийн хүрээнд зарцуулж эзэмших олгогдсон эрхийн дагуу [illegible] үйл ажиллагааны асуудлыг бие даан шийдвэрлэх.

б/ Авто баазын нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэнтэй шууд харилцах, хөдөлмөр, иргэний болон бусад гэрээ байгуулах, хэлцэл хийх.

в/ Авто баазын захиргааны бусад албан тушаалтан болон салбар нэгжийн дарга, эрхлэгчийг томилох, чөлөөлөх.

5. Авто баазын дарга нь Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, заавар гаргана. Тушаал, зааврыг тухайн авто баазын үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

Гурав: <u>Авто баазын эрх, үүрэг</u>

А: Авто бааз нь дор дурьдсан эрх эдэлнэ.

1. Монгол улсын хууль, тогтоол, эмхүү дүрэм, журмыг мөрдүүлэн байгууллагынхаа дотоод үйл ажиллагааг зохицуулна.

2. Байгууллагын үндсэн хөрөнгө, эд хогшил, мөнгөн хөрөнгийг Монгол улсын хууль, тогтоол, бусад эрх зүйн дагуу захирдуулна.

3. Авто бааз нь байгууллагынхаа дотоод бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, удирдлагын зохион байгуулалт болон салбар нэгжүүдээ бүтцийг батлах, өөрчлөн шинэчилнэ.

4. Өөрийн үйл ажиллагааны талаар тусгай горгаж, түүнийгээ хэрэгжүүлэхэд зохицуулах, түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах эрхтэй.

5. Авто бааз нь эрүүл мэндийн бус үйлчилгээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх тээврийн үнэ тарифыг ашигаартай тогтоон мөрдөх болно.

Б: <u>Хүлээх үндсэн үүрэг</u>

1. Тус авто бааз нь гэрээний үндсэн дээр Эрүүл мэндийн яам, нийслэл хотын эрүүл мэндийн байгууллагуудыг тэр, эмнэлгийн бодлогыг хэрэгжүүлэх, эмчилгээ, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг түргэн гүйцэтгэхэд шаардлагатай эмнэлэг, үйлчилгээний тээврийн хэрэгслээр саадгүй хангах үүрэгтэй.

2. Авто бааз нь эмнэлэг-урьдчилан сэргийлэх болон эмнэлэг, банк, аж ахуйн бусад байгууллагуудын ачааг гэрээгээр хүлээсэн түргэн хугацаанд нь бүрэн тээвэрлэнэ.

3. Авто бааз нь үйлчилгээний тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, түүний аюулгүй ажиллагааг хангах, улсын хэмжээнд авто аж ахуйн талаар гарсан хууль, эрхийн актыг дагаж мөрдөнө.

4. Өөрийн техникийг болон эдийн засгийн давуутай байр суурийг ашиглах, эмнэлэг-урьдчилан сэргийлэх байгууллагыг хохироосон, үндэслэлгүй өндөр үнэ, тариф тогтоож мөрдөхгүй байна.

5. Байгаль орчныг элэх бохирдол, эвдрэл, бусад хортой нөлөөллөөс хамгаалах, өөрийн үйл ажиллагааны буруугаас түүнд учруулсан хохирлыг бүрэн арилгана.

6. Сэлбэг хэрэгсэл, шатах, тослох материал, санхүүгийн бусад нөөцийг зориулалтаар нь зохистой ашиглах, Эрүүл мэндийн байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эмнэлэг үйлчилгээний ажлыг хөнгөн шуурхай зохион байгуулахад байнга анхаарна.

Гурав: Авто баазын үйлчилгээ, нийгмийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаа:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан тээврийн хэрэгслийн паркийг шинэчлэх бөгөөд түүнийгээ хэтийн бодлого чиглэлтэй хэрэгжүүлнэ.

2. Авто машин, сэлбэг хэрэгсэл худалдан авах, засвар үйлчилгээ хийхдээ улс, орон нутгийн төсөв болон өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3. Гүйлтийн норм дууссан буюу засварлах боломжгүй авто машиныг актлах, дэлд бүртгэлээс хасахдаа эрүүл мэндийн системд мөрдөж буй сайдын тушаал, журмыг үндэс болгоно.

4. Авто бааз нь Монгол Улсын хөдөлмөрийн болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажиллагчидтай хөдөлмөрлөх боломж, нөхцөлөөр хангаж, хөдөлмөр хамгаалал- аюулгүй ажиллагааг бүрэн баталгаажуулна.

5. Хөдөлмөрийн хөлсний системийг боловсронгуй болгохын зэрэгцээ жолоочийн гэрээнд заасны дагуу үйлчилгээний ажлын эцсийн үр дүнг харгалзан цалин хөлсийг нэмэгдүүлэх буюу бууруулан олгоно.

6. Ажилчдын ээлж солих график, хөдөлмөр-амралтын горимыг хамт олны саналд тулгуурлан тогтоож мөрдөнө.

7. Монгол Улсын хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн стандартад үндэслэн ажлын байрны нөхцлийг тогтоох, хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллагчдын ажлын цагийг хорогдуулах, тэдэнд зохих хөнгөлөлт олгох, ажлын тусгай хувцас, нэмэгдэл хоол, сүү болон ариутгалын бодисоор хангана.

8. Ажиллагчдын эдийн засаг, техникийн болон эрх зүйн мэдлэг, мэргэжлийн зэргийг дээшлүүлэх, давтан сургах гэрээ, захиалгын үндсэн дээр өөрийн боловсон хүчнийг бэлтгэнэ.

9. Авто баазын үйл ажиллагаа, эмнэлэг, үйлчилгээний чанарыг хэргэлсэн байгууллагын шагналаар ажилчдыг шагнан урамшуулах, улсын болон дээд байгууллагын шагналд тодорхойлох, харин сахилга зөрчих, техникийн осол аваар гаргах, эмнэлэг үйлчилгээнд хариуцлага алдсан тохиолдолд хууль, тогтоолын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10. Байгууллагаас ажилтан нэрт нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгох нөхцөл, журмыг байгууллагын захиргаа тогтооно.

11. Хөдөлмөрийн хөлсний нэгдсэн болон нөөц сан байгуулах түүнийг хуваарилах, зарцуулах журам батлан мөрдөнө.

12. Дотоод нөөц боломжоо ашиглан нэмэгдэл үйлдвэрлэл, үйлчилгээ, туслах аж ахуй эрхлэх, олсон ашгаас ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

## Тав: Санхүүгийн үйл ажиллагаа

1. Авто баазын эд хөрөнгө, үндсэн сан, эргэлтийн болон мөнгөн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцийг багтаасан 25,0 сая төгрөгийн дүрмийн сангаас бүрдэнэ.

2. Аж ахуйн бүрэн тооцоон дээр ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлнэ.

3. Авто бааз нь үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцна.

4. Авто бааз нь санхүүгийн төв байгууллагаас баталсан дансны загвар, нягтлан бодох бүртгэл, тайлан тооцооны маягт загварыг мөрдөнө.

5. Авто бааз нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, санхүүгийн орлого, зарлага бүрийг зохих журмын дагуу бэлтгэгдсэн анхан шатны ба нягтлан бодох бүртгэлд тусгаж баримтжуулна.

6. Үйлдвэрлэл, үйлчилгээ аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан тэнцэл, статистикийн мэдээг батлагдсан маягтаар сар, улирал бүр өсөн дүнгээр гаргаж харьяалагдах санхүүгийн байгууллагаар хянуулж, улсын статистикийн албанд тогтоосон хугацаанд хүргүүлж, мэдээ тайлангийн үнэн зөвийг хариуцна.

7. Авто бааз нь статистикийн байгууллагаас батлаагүй маягтаар мэдээ, тайлан гаргахыг татгалзах эрхтэй бөгөөд статистикийн байгууллага түүний үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

8. Авто бааз нь тайлан тэнцэл гаргахын өмнө эд хөрөнгийнхөө тооллогыг тогтоосон журмын дагуу зохион явуулж харилцагч бүрийн тооцоог бодож, үр дүнг бүртгэл, тайланд бүрэн гүйцэт тусгахын хамт өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулна.

9. Авто баазын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг тус бааз өөрөө болон түүнчлэн эрх бүхий бусад байгууллага хянаж шалгана.

Энэхүү хяналт шалгалтын үр дүн нь хөдөлмөрийн хамт олонд ил тод байх ёстой.

Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны даргын 1992 оны 1/126 /212/ тоот хамтарсан тогтоолын гурав-дугаар хавсралт

# ХОТЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АВТОБААЗААС ЭМНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТОБААЗАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| N | Автомашины | | | Жолоочийн нэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | Марк | Улсын дугаар | Бүх гүйлт км | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1. | ГАЗ-24-03 | УБЯ 0318 | 162335 | Отгонбилэг | |
| 2. | ГАЗ-24-03 | УБЯ 0320 | 147264 | Баярсайхан | |
| 3. | ГАЗ-24-03 | УБЯ 0323 | 106913 | Билэгсайхан | |
| 4. | ГАЗ-24-03 | УБЯ 0346 | 210129 | Бадрах | |
| 5. | ГАЗ-24-03 | УБЯ 0404 | 125398 | Сэнгээ | |
| 6. | ГАЗ-24-03 | УБЯ 0426 | 60596 | Лхагвасүрэн | |
| 7. | ГАЗ-24-03 | УБЯ 0446 | 87349 | Ганбаяр | |
| 8. | ГАЗ-24-03 | УБЯ 0447 | 105351 | Ганбаатар | |
| 9. | ГАЗ-24-03 | УБЯ 0465 | 89349 | Ням-Осор | |
| 10. | ГАЗ-24-03 | УБЯ 4266 | 219737 | Эрдэнээ | |
| 11. | ГАЗ-24-03 | УБЯ 6915 | 255461 | Баасанбат | |
| 12. | ГАЗ-24-03 | УБЯ 0329 | 70676 | Батжаргал | |
| 13. | РАФ-2203 | УБЯ 0007 | 199756 | Хөвөөш | |
| 14. | РАФ-2203 | УБЯ 0023 | 157313 | Хүрэлбаатар | |
| 15. | РАФ-2203 | УБЯ 0267 | 181245 | Зориг | |
| 16. | РАФ-2203 | УБЯ 0269 | 121648 | Эрдэнэбаяр | |
| 17. | РАФ-2203 | УБЯ 0334 | 115097 | Сүхбаатар | |
| 18. | РАФ-2203 | УБЯ 0336 | 124347 | Сундуй | |
| 19. | РАФ-2203 | УБЯ 0337 | 140973 | | |
| 20. | РАФ-2203 | УБЯ 0338 | 79918 | Э.Болдбаатар | |
| 21. | РАФ-2203 | УБЯ 0341 | 143958 | Эрдэнээ | |
| 22. | РАФ-2203 | УБЯ 0350 | 173410 | Шонхор | |
| 23. | РАФ-2203 | УБЯ 0370 | 93844 | Эрдэнэбаяр | |
| 24. | РАФ-2203 | УБЯ 0383 | 142706 | Далбадрах | |
| 25. | РАФ-2203 | УБЯ 0406 | 137706 | Мягмархүү | |
| 26. | РАФ-2203 | УБЯ 0409 | 124826 | Бямбацогт | |
| 27. | РАФ-2203 | УБЯ 0430 | 91205 | Гийнаа | |
| 28. | РАФ-2203 | УБЯ 0439 | 88242 | Цэрэнням | |
| 29. | РАФ-2203 | УБЯ 0491 | 37390 | Батсайхан | |
| 30. | РАФ-2203 | УБЯ 0497 | 58613 | Батцэнгэл | |
| 31. | РАФ-2203 | УБ 2332 | 163965 | Б.Ганболд | |
| 32. | РАФ-2203 | УБ 3092 | 148197 | Ганболд | |
| 33. | РАФ-2203 | УБ 3644 | 193156 | Ганбат | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| 34. | РАФ-2203 | УБ 4191 | 182187 | Мэнд-Аюуш | |
| 35. | РАФ-2203 | УБ 5249 | 211093 | Пүрэвсүрэн | |
| 36. | РАФ-2203 | УБ 5598 | 144683 | | |
| 37. | РАФ-2203 | УБ 7805 | 151806 | Мягмарсүрэн | |
| 38. | РАФ-2203 | УБ 8574 | 199334 | Түмэн-Өлзий | |
| 39. | РАФ-2203 | УБ 9032 | 158502 | Батсайхан | |
| 40. | РАФ-2203 | УБЯ 0435 | 101500 | Олзвой | |
| 41. | РАФ-2203 | УБЯ 0879 | 138857 | Ариунсан | |
| 42. | Москвич | УБЯ 0013 | 150543 | Лхам | |
| 43. | Москвич | УБЯ 0033 | 128100 | Даарийнаа | |
| 44. | Москвич | УБ 0079 | 60013 | Эрдэнэчулуун | |
| 45. | Москвич | УБЯ 0250 | 91161 | Туул | |
| 46. | Москвич | УБЯ 0253 | 156604 | Хүрэлбаатар | |
| 47. | Москвич | УБЯ 0255 | 145937 | Цэрэндулам | |
| 48. | Москвич | УБЯ 0303 | 159978 | Зориг | |
| 49. | Москвич | УБЯ 0308 | 116901 | Нямдорж | |
| 50. | Москвич | УБЯ 0309 | 91027 | Гантулга | |
| 51. | Москвич | УБЯ 0365 | 87600 | Наранбулаг | |
| 52. | Москвич | УБЯ 0389 | 108161 | Р.Батсүх | |
| 53. | Москвич | УБЯ 0836 | 134269 | Б.Батсүх | |
| 54. | Москвич | УБЯ 6463 0085 | 125562 | Лхагважав | Актлагдах |
| 55. | ГАЗ-66 | УБЯ 0219 | 7443 | Байгал | |
| 56. | ГАЗ-66 | УБ 2067 | | | |

Үүнээс : ГАЗ-24-03 - 12 ширхэг
РАФ-2203 - 29 ширхэг
Москвич - 13 ширхэг
ГАЗ-66 - 2 ширхэг

16

Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны даргын 1992 оны А/126/212 тоот хамтарсан тогтоолын дөрөвдүгээр хавсралт

## Эмнэлэг үйлчилгээнд бие даан ашиглах авто машины жагсаалт

| N | Эмнэлэг байгууллагын нэр | Машины Тоо | Марк | номер | Аль байгууллагаас шилжүүлэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | Шүүх эмнэлгийн магадлах товчоо | 2 | РАФ 2203 | УБЯ 0340<br>УБЯ 0021 | ХТТАБаазаас |
| 2. | Эмгэг анатомийн товчоо | 2 | РАФ 2203 | УБЯ 0486<br>УБЯ 0328 | ХТТАБаазаас |
| 3. | Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар | 1 | Москвич | УБ 8819 | ЭМЯ-ны авто баазаас |
| 4. | Клиникийн нэгдсэн I эмнэлэг | 2 | ГАЗ-24-03<br>РАФ 2203 | УБЯ 0316<br>УБЯ 0335 | ХТТАБаазаас |
| 5. | Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэг | 2 | УАЗ-452А<br>РАФ 2203 | УБ 0918<br>УБЯ 0484 | ЭМЯ-ны авто баазаас |
| 6. | Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институт | 1 | Москвич | УБЯ 0311 | ЭМЯ-ны авто баазаас |
| 7. | Халдваргүйтгэлийн төв | 1 | РАФ 2203 | УБЯ 0378 | ХТТАБаазаас |
| 8. | Гачууртын их эмчийн салбар | 1 | РАФ 2203 | УБЯ 0498 | ХТТАБаазаас |
| 9. | Налайхын Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар | 1 | РАФ 2203 | УБЯ 0371 | ХТТАБаазаас |
| 10. | Ажилчин дүүргийн хүүхдийн нэгдсэн эмнэлэг | 1 | РАФ 2203 | УБЯ 5999 | ХТТАБаазаас |
| 11. | Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төв | 1 | Москвич | УБЯ 0390 | ХТТАБаазаас |
| 12. | Багануурын нэгдсэн эмнэлэг | 2 | РАФ 2203 | УБЯ 0330<br>УБЯ 0313 | ХТТАБаазаас |
| 13. | Рашаан судлалын төв | 1 | РАФ 2203 | УБЯ 0284 | ХТТАБаазаас |
| | БҮГД | 18 | | | |

Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын Ардын журдын гүйцэтгэх захирлааны даргын 1992 оны 1/726/ААА тоот хамтарсан тогтоолын тав-дугаар хавсралт

ЭМНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТОБААЗААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГА

1. Эрүүл мэндийн яам
   Үүнээс : -Төв аппарат
   -Алсын түргэн тусламжийн дуудлага
   -Эмнэлэг дундын үйлчилгээ

2. Анагаах ухааны хүрээлэн
3. Анагаах ухааны их сургууль
4. Ардын эмнэлгийн хүрээлэн
5. Эх,хүүхдийн эрдэм шинжилгээний төв
6. Сэтгэцийн эмгэг судлалын төв
7. Хавдар судлалын төв
8. Мэргэжлийн өвчин судлах төв
9. Монгол эмнэлэг сувилалын төв
10. Арьс өнгөний эмгэг судлалын төв
11. Арьс өнгөний эмгэг эмчлэх клиник
12. Эмнэлэг биеийн тамирын төв
13. Сүрьеэ судлалын төв
14. Сүрьеэгийн клиник
15. Хүүхдийн сувилал
16. Анагаах ухааны мэргэжил дээшлүүлэх институт
17. Сувилагчийн дунд сургууль
18. "Эмийн үйлдвэр" компани
19. Хотын эмийн бааз
20. Эм шалгах төв лаборатори
21. Эрүүл ахуй, халдвар,нян судлалын улсын институт
22. Эрүүл мэндийн сургалт, арга зүйн төв
23. Элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлэг
24. Халдварт өвчин анагаах клиник
25. Рашаан судлалын төв
26. "Оргил" рашаан сувилал
27. Хоол судлалын төв
28. Эмнэлгийн техник компани
29. Гоо засалын газар
30. Цус сэлбэх судлалын төв
31. Эмийн сангийн төв N 1, 2, 3, 4, 5, 6
32. Нүдний шилний үйлдвэр
33. Зүү тариурын үйлдвэр
34. Протезийн үйлдвэр
35. Эрүүл мэндийн газрын туслах үйлдвэр /оёдол-нэхий/
36. Хотын Эрүүл мэндийн газар
37. Клиникийн N нэгдсэн эмнэлэг
38. Нөхөн сэргээх төв
39. Гэмтэл согогийн эмнэлэг

40. Хүүхдийн клиникийн сувилал
41. Элэг цөсний өвчтэй хүүхдийн сувилал
42. Клиникийн I амаржих газар
43. Клиникийн II амаржих газар
44. Клиникийн III амаржих газар
45. Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төв
46. Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг
47. Сүхбаатар дүүргийн хүүхдийн нэгдсэн эмнэлэг
48. Эрүүл мэндийн төвүүд N 1, 2, 3, 16
49. Сүхбаатар дүүргийн сүрьеэ, арьс өнгө, хавдар судлалын диспансерууд
50. Сүхбаатар дүүргийн эрүүл ахуй,халдвар судлалын хяналтын газар
51. Уушгины сүрьеэгийн клиник
52. Октябрь дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төв
53. Октябрь дүүргийн нэгдсэн эмнэлэг
54. Октябрь дүүргийн хүүхдийн нэгдсэн эмнэлэг
55. Октябрь дүүргийн эрүүл мэндийн төвүүд N 4, 5, 6, 7, 8, 14
56. Октябрь дүүргийн арьс өнгө, сүрьеэ, халдвар судлалын диспансерууд
57. Октябрь дүүргийн эрүүл ахуй,халдвар судлалын хяналтын газар
58. Найрамдал дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төв
59. Найрамдал дүүргийн нэгдсэн эмнэлэг
60. Найрамдал дүүргийн хүүхдийн нэгдсэн эмнэлэг
61. Найрамдал дүүргийн эрүүл мэндийн төвүүд N 9, 10, 15
62. Найрамдал дүүргийн сүрьеэ, арьс өнгө, халдвар судлалын диспансерууд
63. Найрамдал дүүргийн эрүүл ахуй,халдвар судлалын хяналтын газар
64. Ажилчин дүүргийн эрүүл мэндийн зөвлөх төв
65. Ажилчин дүүргийн нэгдсэн эмнэлэг
66. Ажилчин дүүргийн хүүхдийн эмнэлэг
67. Ажилчин дүүргийн эрүүл мэндийн төв N 13
68. Ажилчин дүүргийн сүрьеэ, арьс өнгө, халдвар судлалын диспансерууд
69. Ажилчин дүүргийн эрүүл ахуй,халдвар судлалын хяналтын газар
70. Хотын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар

БҮГД 87 байгууллага.